



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

2019 оны бие бүрэлдэхүүний сургалт
бэлтгэлийн төлөөлөгөө, хөтөлбөр батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2, 13.3.5, 30 дугаар зүйлийн 30.3, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн "Сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай" А/309, 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн "2019 оны сургуулийн жилд сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай" А/437 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2019 оны сургуулийн жилийн удирдамжийг нэгдүгээр, 2019 оны сургалт бэлтгэлийн төлөөлөгөөг хоёрдугаар, сургалтын хөтөлбөрийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургуулийн жилийн нээлтийг 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж, дүнг 01 дүгээр сарын 17-ны өдрийн дотор цахимаар, бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулж, сургуулийн жилийн эхний хагасын дүнг 05 дугаар сарын 28, сургуулийн жилийн дүнг 12 дугаар сарын 06-ны өдрийн дотор Захиргааны удирдлагын хэлтэст ирүүлэхийг дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, нийслэлийн Аврах анги-105-ын захирагч, Иргэдийг Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Сургуулийн жилийн явц, үр дүнд хяналт тавьж удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д тус тус даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА  ХЧҮЛТЭМСҮРЭН

